


НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ, ОНЦЛОГ

Хэнтий аймгийн Галшар сум нь Богд хаант Монгол улсын үед Сэцэн хан аймгийн Бишрэлт вангийн хошуу хэмээн нэрлэгдэж байсан ба 1923 онд Хан Хэнтий уулын аймаг байгуулагдахад Галшар уулын хошуу нэртэйгээр байгуулагдсан ууган сумдын нэг билээ. Ардын засгийн жилүүдэд Хан Хэнтий уулын Галшар уулын хошуу хэмээн нэрлэгдэж байгаад 1931 онд хоёр хэсэг буюу Галшар, Буянт сум болгон өөрчлөгдсөн. Түүнээс хойш хамгийн сүүлд 1979 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн 301-р зарлигаар дахин нэгтгэж Галшар сум болгон Буянт сумын төвд төвлөрүүлсэн түүхтэй билээ. Галшар сум нь Арвин 1-р баг, Оч 2-р баг, Баянбадрал 3-р баг, Сангийндалай 4-р баг, Жаргалант 5-р баг, Буянтбулаг 6-р баг гэсэн засаг захиргааны 6 багтай.



Газар зүйн байршил

Хэнтий аймгийн урд хэсэгт байрладаг.

- Улаанбаатар хотоос 460 км,
- Зүүн талаараа Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түвшинширээ сум, өмнөд хэсгээрээ Дорноговь аймгийн Дэлгэрэх, Алтанширээ, Их хэт сум, баруун болон хойд хэсгээрээ өөрийн аймгийн Баянмөнх, Баянхутаг зэрэг 3 аймгийн 7 сумдуудтай хиллэн оршдог

БАЙГАЛЬ, ГАЗАРЗҮЙН ОНЦЛОГ

Газарзүйн онцлог. Тус сум нь 667608 га нутаг дэвсгэртэй, газарзүйн хувьд тал хээрийн бүсэд харъяалагддаг боловч говийн байдал зонхилсон хэв шинжтэй. Газар нутгийн хэмжээгээр аймагтаа 2-т ордог уужим нутагтай.

Цаг уурын нөхцөл: 2017 оны хамгийн дулаан +35.3 хэм, хамгийн хүйтэн -35.7 хэм болж хүйтэрч байсан.

- Тунадас нийт 167.3, дундаж 0.4
- Салхи дундаж 4м/сек
- Салхи хамгийн их 25м/сек

Газар нутаг: Нийт газар нутгийн хэмжээ **667608 га**. Үүнээс:

Зориулалт	Хэмжээ /га/	Нийт талбайд эзлэх хувь
Хөдөө аж ахуйн газар	663342,7	99,3
Ойн сан бүхий газар	0	0
Усан сан бүхий газар	1302	0,1
Тусгай хэрэгцээний газар	1	0
Тосгон, суурингийн газар	565.5	0,08
Зам шугам сүлжээний газар	2396.8	0,35




ГАЛШАР СУМЫН СҮЛД

2003.01.27-ны өдөр ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 05-р тогтоолоор уран бүтээлч Г.Хэрлэнмөнхийн “Хийморь” сэдэвт бүтээлийг бүтээлийн чанар чансаа, ур хийцийг үнэлэн сумын сүлд тэмдгээр шалгаруулсан.

ГАЛШАР СУМЫН ТУГ

Галшар сумын туг нь шар өнгийн дэвсгэр дээр давхиж байгаа морийг гол хэсэгт нь цэнхэр өнгөөр, дээд хэсэгт нь гал нар сарыг улаан өнгөөр, Галшар гэж уйгаржин монгол үсгээр тус тус ялган дүрсэлсэн. Тугны өргөн, урт нь 200*100 см хэмжээтэй байна.



ГАЛШАР УУЛ

Галшарчуудын шүтээн тахилгат Их уул
далайн түвшнээс дээш 1597 м

/Аймгийн ИТХ-ын 2009 оны 02-р тогтоолоор тус уул орчмын 6500 га газар нутгийг аймгийн тусгай хамгаалалтанд авсан/

ХҮН АМЫН ТОО, ЁС ЗАНШИЛ, СОЁЛ УЛАМЖЛАЛ

Хүн ам, өрхийн тоо

Үзүүлэлт	Сумын төвд	Хөдөөд	Нийт
Хүн амын тоо	413	1781	2194
Нийт эрэгтэй			1133
Нийт эмэгтэй			1031
0-4 нас			252
5-9 нас			204
10-14 нас			172
15-18 нас			176
19-24 нас			265
25-29 нас			156
30-34 нас			161
35-39 нас			174
40-44 нас			161
45-49 нас			142
50-54 нас			119
55-59 нас			93
60-64 нас			44
65-аас дээш нас			74
Өрхийн тоо	151	580	731
Суурин хүн ам			2194

Хүн амын шилжит хөдөлгөөн

	2014	2015	2016
Шилжин ирсэн	75	51	106
Шилжин явсан	116	139	109
Цэвэр шилжилт хөдөлгөөн	-41	-88	-3

Тус сум нь 3 аймгийн 7 нийслэл хаяа нийлэн оршдог бөгөөд нийт хүн амын 30-аа хувь нь сумын төвд амьдардаг.

Сумын нийт хүн амын 779 буюу 36,9 хувь нь хүүхэд, 726 буюу 34,4 хувь нь залуучууд болон дунд насныхан, 604 буюу 28,6 хувь нь ахмад настан байна. Нийт хүн амын 97 орчим нь Халх, үлдсэн нь Урианхай, Буриад, Казак, Дархад ястанууд эзэлдэг.



СУМЫН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

ГАЛШАР АДУУ

“Галшар” адуу нь 2007 онд үндсэн сайжруулагчаар батламж авч 2016 онд Монгол улсад АНХ удаа Галшар адууг “ҮҮЛДЭР” болгон баталгаажуулсан.

2014, 2015 оны “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” улсын үзэсгэлэн худалдаанд Шилмэл мал төрөлд “Галшар адуу” нь тэргүүн байрыг эзэлсэн.

Галшарын үүдэрийн Хонгор азарга 1989 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Шилмэл мал улсын үзэсгэлэнд амжилттай оролцож тэргүүн байр алтан медаль, 2011 онд Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан зүүн бүсийн үзэсгэлэнд Бор халзан гүү дэд байр мөнгөн медаль, 2015 онд Монгол Улсын Шилмэл мал үзэсгэлэнд М.Төмөрбаатарын Халтар азарга шилдэг хээлтүүлэгчээр тэргүүн байр, Д.Энхтайваны Ногоон гүү Шилдэг хээлтэгчээр тэргүүн байр, Т.Төрмөнхийн Цагаан гүү хээлтэгч төрөлд дэд байр, Р.Ачтайн Хээр азарга хээлтүүлэгч төрөлд тусгай байр тус тус эзэлж шагнагдсан амжилт гаргасан.



“Галшар адууны баяр” арга хэмжээг аймгийн Засаг даргын ивээл дор Соёл спортын газар, Сэцэн хааны музейтэй хамтран 2014 оноос уламжлал болгон 4 дэх жилдээ зохион байгуулж байна. Энэхүү арга хэмжээгээр Монгол хүү бага наадам, адуучин, 2 насны морь уралдуулж, Сайхан наадамчин тэмцээнүүдийг зохион явуулж хэвшээд байна. 2015 онд МҮОНРТВ-ээс эрхлэн явуулдаг “Морьтон Монгол” жагсаалыг зохион байгуулж хамгийн олон буюу 450 гаруй морьтоны жагсаал болсон.



Галшар адуу үүсэн бүрэлдэж, үржиж олшроод хурдан хүлэг халх даяар алдаршаад 100 гаруй жил болжээ. Галшар “Адуу” 2007 онд үндсэн сайжруулагчаар батламж авч 2016 оны 06-р сард Монгол улсад анх удаа “Галшар үүлдэрийн адуу” гэрчилгээг авсан.



Манай сум 2016 оны эцэст 21451 адуу тоолуулсан ба Хоёр Түмэн адууны баяраа 2017 оны 07-р сард тэмдэглэж алдарт уяачид, адуугаа алдаршуулсан билээ. Галшар сумаас улсын баяр наадмаас 56 түрүү, 165 айраг, даншгийн наадмаас 9 түрүү 26 айраг, Хан Хэнтий уулын аймгийн наадмаас 56 түрүү 178 айраг авсан байдаг.

Хардэл жанжин бэйс М.Пүрэвжавын Огтор хонгор, Мойног хонгор, Оонон хар, Мэнгэт халиун, Зандан буурал, Элбэг хээр, Идэр хээр, Саруул хээр, Эсгэл халтар, Хэнз халтар, Тонж ногоон, Дагмид-Очир мээрэнгийн сайхан хонгор, Шил зээрд, Норов хүрэн зэрэг 30 гаруй хурдан удмын адууг одоо үржүүлж байгаа 19100 адуу удмын сан болон хадгалсаар байна. 2014 онд Баянбадрал багийн Улсын сайн малчин Т.Төрмөнх 155 унага бойжуулж 660 адуу тоолуулсан амжилтаар МҮОНРадиоогын “Алтан унага”-ны эзнээр тодорсон амжилт гаргасан.

Манай сум нь “Хэцийн хүрэн” удмын тэмээтэй бөгөөд Хэнтий аймгаас зохион байгуулдаг “Нэг суурин нэг бүтээгдэхүүн аймгийн үзэсгэлэн худалдаанаас буур Шилмэл малаар 3 удаа шалгарсан амжилттай.



ГАЛШАРЫН УЛААН ЯМАА

2007 онд Нэг суурин нэг бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдаанаас “Улаан ямааны ноолуур” шилдэг БРЭНД бүртээгдэхүүн, 2007 онд Галшар улаан ямаа нь үндсэн сайжруулагчийн шалгарч батламж авсан. 2009 онд ямаан сүргийн тоо өсөлтийг гурван бүс болгон хувааж Галшарын улаан ямаан сүргийн талаар олон жилийн судалгаанд үндэслэн аймгийн үржил селекцийн станцаас 1987-1988 онд үзлэг ангилалт хийж ноолуурын гарц, төлийн амьдрах чадвар нь аймгийн дунджаас **Үлэмж** дээгүүр болохыг тогтоосон юм. Аймгийн нийт ямаан сүргийн 9.1%-ийг Галшарын улаан ямаа эзэлдэг ба говь цөлөрхөг нутагт дасан зохицсон. Ноолуурын гарц нь бүдүүн ухна 500гр, эр ямаа 800-950гр, эм ямаа 400-500гр, борлон 360-450гр гардаг, амьдын жин бүдүүн ухна 63кг, эм ямаа 51кг-г татдаг, ноолуур нь нарийн урт зөөлөн бат бөх жигдлэг чанартай, бэлтгэсэн ноолуурын 98,2% нь Нэгдүгээр зэрэгт тэнцдэг сайн



чанарын ноолууртай.

Сангийндалай багийн малчин Г.Гарамжавын улаан ухна 2012-2016 онуудад аймгийнхаа “Шилмэл мал” үзэсгэлэнд амжилттай оролцож тэргүүн байруудыг эзэлсэн ба амьдын жин 79-87,4кг хүртэл татаж жил тутам 1,1кг ноолуур өгдөг гойд ашиг шимт малаар шалгарсаар байна. Улаан ямааны үүлдэрлэг байдал, ашиг шимийн үзүүлэлтийг МААЭШХ-тэй хамтран судалгааны баг ажиллуулж омог хэвшлийг тогтоохоор судалгаа шинжилгээний ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдэж байна.



ДАРШЛАСАН ХӨМҮҮЛ

Иргэдийн амтархан идэх дуртай, хоолны амт чанарт дээд зэргийн хачир болон хэрэглэгддэг энэхүү даршласан хөмүүл нь 2008-2017 онд Нутгийн брэнд бүтээгдэхүүнээр шалгарч Намрын баяр - Нэг суурин нэг бүтээгдэхүүн аймаг, сумын үзэсгэлэн худалдаануудад амжилттай оролцож байна.

МАЛЫН ТОО, АНГИЛАЛ

Мал сүргийн сүүлийн 5 жилийн судалгаа


2016 оны жилийн эцсийн байдлаар 295895 толгой малтай. Сүргийн бүтцийн хувьд Тэмээ– 480, Адуу– 21451, Үхэр–14729, Хонь–149622, Ямаа–109613 толгой тус тус эзэлж

№	Он	2012	2013	2014	2015	2016
---	----	------	------	------	------	------

байна. 580 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 79,3 хувийг эзэлж байна. Галшар сум хурдан удмын адуу, ноолуурын чиглэлийн улаан ямаагаараа аймаг, улсдаа алдартай. Галшарын улаан ямаа нь 1988 оноос эхлэн амьдын жин, ноолуурын гарцаараа Хэнтий аймагтаа тэргүүлж эхэлсэн ба 2007 онд аймгийнхаа үндсэн сайжруулагчаар батламжлагдан бусад сумдуудад үржилд ашиглагдан ноолуур ихтэй үнэт сүрэг бий болгосоор байна.

2012 оноос мал сүрэг 5 төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна. Нийт мал сүргийн 87 хувийг бог мал буюу хонь, ямаа эзэлж байдаг.

1	Малын нийт тоо	207243	232272	259995	281802	295895
2	Тэмээ	465	490	464	472	480
3	Адуу	12712	14501	16764	19100	21451
4	Үхэр	9570	11026	12655	13652	14729
5	Хонь	101224	113778	126388	139465	149622
6	Ямаа	83272	92477	103724	109113	109613



Ургамал:

Агаар хөрсний чийгийн хангамжийг даган үлэмж сийрэг, тачир таруу болдог. Зонхилох ургамал нь бутлаг үетэн, шивээт, хялгана, хиаг, саман ерхөг, агь, хөмүл, таана тааралдана. Хужир марзтай хонхор газруудаар дэрс, бударгана, лууль ургана. Тал хээрийн бүсийн экосистем ихээхэн эмзэг байдаг нь зүйлийн бүрэлдэхүүн цөөн, хөрсжилт нимгэн, усан хангамж тааруу, салхины нөлөө ихтэй, гангын давтамж өндөр зэрэгтэй холбоотой. Хөмүл таана нутгийн бренд бүтээгдэхүүн юм. Тал хээр бол Мал аж ахуй, Газар тариалангийн бүс нутаг юм.



Тус суманд цагаан зээр, аргаль, идлэг шонхор, хар сүүлт, талын чоно, үнэг, хярс зэрэг ан амьтан, жигүүртэн шувууд нутагладаг.



Идлэг шонхор:

Амьтны аймаг хөвчтөн ба сээр нуруутны төрөлд багтдаг өдрийн махчин шувуутан юм. Идлэг шонхорын нэг хос 4-5 өндөг гаргаж 40-50% нь бойждог. 2010 онд идлэг шонхорыг хамгаалах зорилгоор Төв,

lshar@yahoo.com Мэдээллийг 2016 оны жилийн эцсийн байдлаар гаргасан болно.
ар сум – Миний нутаг

Дундговь, Дорноговь, Хэнтий, Сүхбаатар аймгуудын 20 суманд идлэг шонхорын хиймэл үүр төсөл хэрэгжсэний нэг нь манай сумын Арвин, Оч, Сангийндалай багийн нутаг дэвсгэрт 250ш хиймэ үүр байршуулж идлэг шонхор таатай өсөн үржих нөхцөл бүрдсэн.

Цагаан зээр:

Монгол орны уудам тал, ухаа толгодоор идээшин бэлчдэг. Манай суманд 6000-10.000 орчим цагаан зээр нутагшдаг. Цагаан зэрийн эрэгчинг ооно, эмэгчинг шаргачин, төлийг янзага, эрэгчин шүдлэнг цэнхэр ооно, охин шүдлэнг зусаг шаргачин гэнэ. Голдуу хул шар зүстэй, богино сүүлтэй, тангийнхаа захаар шар хүрээтэй, шаргачин нь эвэргүй, ооно нь шорон 2 эвэртэйгээрээ хар сүүлт зэргээс ялгаатай. 6-р сард янзагалаана. Цагаан зээр нь хялгана, шаваг, хазаар өвс үет ургамлаар хооллоно.



Хар сүүлт:

Хөхтөн амьтны аймгийн нэг, туурайтны баг болох тугалмайтны овогт багтана. Уулсын бэлийн хялганат баглуурт сайр, хэвгий тал, загт бударгана, говь сундуул бүхий бут сөөгт элсэрхэг говь орчимд байршдаг. Манай сумын Оорцог, Агтан, Шазуурын толгодоор цөөн тоогоор нутагшдаг. Эрийг нь Ооно, эмийг нь Шаргачин, төлийг нь янзага гэнэ. Зүс нь элсэн саарал ухаа, мөч цайвар, бөгс сүүлийн угнаас дээш үе хэтрэх цагаан танатай.

Аргаль хонь:

Хөхтөн аймгийн амьтны нэг. Хос туурайтны баг болох тугалмайтны овогт багтана. Өндөр нам уулс, Аараг толгод зэрэг нугачаа сархиа бүхий задгай газар нутаглана. Монгол улс 1953 оноос эхлэн Аргаль агнахыг хуулиар хориглон дархалсан. Биеийн ерөнхий төрхөөр Монгол хоньтой адил төстэй боловч байгалийн нөхцөлд зохицож хөл нь өндөр нарийхан зэгзгэр, үс ноос нь тачир, ширүүн годгор жижиг сүүлтэй. Эрийг нь угалз, эмийг нь аргаль, төлийг нь хурга гэнэ. Манай сумын Их Арт, Баянмөнх, Бага Арт, Үнэгд, Галшар уулуудаар 54 орчим аргаль нутагшин сүрэглэн бэлчдэг.



ТҮҮХИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН МЭДЭЭЛЭЛ



Хөшөө дурсгалын нэр: “Хурдан морь”-ны хөшөө. Байгуулагдсан он: 1989 он

Хөшөө, дурсгалын намтар: Уг хөшөөг сум, нэгдлийн дарга байсан Наваанмөнхийн Дэрийлаагийн санаачлагаар Буянт-Оргил нэгдлийн хөрөнгөөр зураач, барималчин Л.Давааням, Д.Батхуяг, гагнуурчин Н.Пүрэвбанзрагч нар бүтээжээ. Халхын хурдны өлгий нутгийг босоо багана, үүлэн дотор давхиж яваа морьд бүхий сүрлэг зохиомжоор төлөөлүүлж, гөхөл сүүлийг нь боосон **“Өлгөр хүрэн”** хэмээх азарганы хийморьлог дүрийг урлан бүтээсэн юм. Өвгөн ноён Пүрэвжавын домогт хурдан азаргануудын нэг, адуунд байхдаа толгой нь ганцаараа морьтой хүн шиг харагддаг байжээ. Өвгөн ноён өлгөр хүрнээ хялгасан бийрээр зурсан зураг нь эдүгээ зураач Л.Даваанямд хадгалагдаж байна. 2015 онд ИТХурлын тогтоолоор “Сумын 9-н гайхамшиг”-н нэгээр бүртгэгдсэн.

Хөшөө дурсгалын нэр: **“Өвгөн ноёны дурсгал”**-ын гэрэлт хөшөө. Байгуулагдсан он: 1997 он

морин



нэр: “

Хөшөө, дурсгалын намтар: Монголын спортын уяачдын холбооны тэргүүн асан У.Буяндэлгэрийн санаачлагаар Галшар сумын Хужирт хэмээх газарт Өвгөн ноёны хурдны шөрмөсөн чулуут довон дээр энэхүү гэрэлт хөшөөг босгосон. 2015 онд ИТХурлын тогтоолоор “Сумын 9-н гайхамшиг”-н нэгээр бүртгэгдсэн. Хөшөөны эх загварыг Морин соёл судлаач Ж.Саруулбуян зохиож нутгийн хүү Сандуйн Жаргал ивээн тэтгэжээ.

Хөшөө
дурсгалын



аймгийн
Галшар

Хөдөлмөрийн баатар, партизан Л.Дамдинсүрэн”-ийн хөшөө.

Байгуулагдсан он: 2011 он

Хөшөө, дурсгалын намтар: Сэцэнхан Хардэл жанжин бэйсийн хошууны нутаг суманд төржээ.1921 онд зүүн хязгаарын цэрэгт татагдан цагаантантай тулалдахад оролцжээ. 1924-1949 он хүртэл орон нутгийн засаг захиргааны байгууллагад ажиллаж байв. 1957 оноос нэгдлийн гишүүн болж хонийг бэлчээрээр таргалуулахад онцгой амжилт гаргасан учир аймаг байгуулагдсаны 40 жилийн ойгоор 1963 онд **“Хөдөлмөрийн баатар”** цол хүртжээ. Ардын Хувьсгалын 25, 40 жил, Халх голын 30 жил, Бид ялав зэрэг ойн медалиудтай.

Халх голын 75 жилийн ойг тохиолдуулан Эрэлхэг эх оронч, 6-р морьт дивизийн дарга Ч.Шаарийбуугийн амь эрсдсэн газар Халх голд хүндэтгэлийн гэрэлт хөшөөг 2014 онд босгов.





Сүмийн хад

Байгалын өвөрмөц тогтоц бүхий дурсгалт газар сумын төвөөс зүүн тийш 25км зайд орших бөгөөд Хатан, Ноён суудал, Эртний хүн амьдарч байсны ул мөр болох агуй, Эмээл ташуур уурганы тавиур, Адууны хорио, Тогтоол цөөрөм



зэргүүдээрээ гайхагдаж сумын ИТХурлын тогтоолоор “Сумын 9-н гайхамшиг”-н нэгээр бүртгэгдсэн.



Бага Артын Чингисийн зам

Хэнтийн аймгийн Галшар сумын төвөөс зүүн хойш 30км, Бага Арт зүүн доогуур баруун

урагш чиглэсэн чулуун далан 5км үргэлжилнэ. Энэхүү чулуун даланг нутгийнхан Чингисийн зам гэх бөгөөд Хэнтий аймгийн ИТХ-н тогтоолоор Түрэгийн үеийн дурсгалаар бүртгэгдэн хамгаалалтанд авсан.



Бичигтын хадны зураг, чулуун зэвсгийн дурсгалт газар



Бичигт хадны сийлмэл зураг /зүүнээс/ Хэнтийн аймгийн Галшар сумын төвөөс зүүн хойд зүгт 40 гаруй км, Бага Арт уулын хойд талд Бичигт хад хэмээх газар хэдэн сийлмэл зураг бий.

Бичигт хадны орчмын чулуун Зэвсгийн үлдэгдэл





Зараагийн энгэрийн дөрвөлжин булш /зүүн урдаас болон урдаас/


Хэнтийн аймгийн Галшар сумын төвөөс баруун тийш 15-17 орчим км, Дондойн Зараа уулын энгэрт дөрвөлжин булш, хиргисүүр, тахилын байгууламж нийлсэн 30 гаруй дурсгал бий.

Цацын голын хөшөө чулууд

Хэнтийн аймгийн Галшар сумын төвөөс баруун зүгт 30-аад км-т, Цацын голын хөндийд хавтгай чулуун хашлага бүхий хэдэн боржин чулуун хөшөө бий. Эдгээр хөшөө чулуудын ихэнхи нь газарт сул хэвтэх бөгөөд гадаргуу дээр нь ил харагдах зүйл байхгүй ажээ. Түрэгийн үеийн дурсгалаар бүртгэгдсэн:



Цацын голын хөшөө чулууд баруун урдаас болон зүүн урдаас



СОЁЛЫН ҮНЭТ ӨВ



Хардэл Жанжин бэйс өвгөн ноён
М.Пүрэвжавын Ланзан тамга



Монгол Улсын анхны 01 дугаарын үнэмлэхтэй алдарт уяач Донойн Цэвэгмидийн хусуур

1800-аад оны үеэс өвлөгдөж ирсэн
соёлын биет өвүүд



Ногоон дарь эх



Дигваранз хилэнцэт
хорхойн сахиус



Шэйрэвнинбо /есөн эрдэнээр
үрласан сүдар/



БАЙГАЛИЙН БАЯЛАГ, АШИГТ МАЛТМАЛЫН ОРД ГАЗАР

Ашигт малтмал:

Манай орны дорнод Металлогений бүсийн хэмжээнд байрлах ба алт, хайлуур жонш, гянт болд, төмрийн хүдэр, нүүрс, хар тугалга, болор, польметалл зэрэг ашигт малтмалуудын илэрцтэй. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Түүнчлэн тус суманд Нордвинд ХХК, Түмэн ивээл ХХК, Майнерал ХХК, Говьео ХХК зэрэг ашиглалтын 8 лиценз эзэмшигч, Билэг төгсдэлгэрэх ХХК, Дорногольд ХХК, МАК цемент ХХК, Түлэресорс ХХК зэрэг 10 хайгуулын лиценз эзэмшигч үйл ажиллагаа явуулж байна.



ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЭЦ

Орон нутгийн төсөв

2016 онд сумын төсвийн нийт орлого нь 1264,7 сая төгрөг бөгөөд улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг 869,5 сая төгрөг, сумын өөрийн орлого 47,9 сая төгрөгийн орлогоос бүрддэг. Орон нутгийн нийт төсвийн зардал нь 1264,7 сая төгрөг байна.

Эдийн засгийн бүтэц

Сумын хэмжээнд нийт 20 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж нийт 403,8 сая төгрөг, улсын төсөвт 176,7 сая төгрөг, аймагт 100,7 сая төгрөг, орон нутагт 54,8 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

Ажиллах хүч салбараар

Салбар	Хэмжих нэгж	2016		
		Сумын төвд	Хөдөөд	Нийт
Аж үйлдвэр	Хүн		49	49
Хөдөө аж ахуй	Хүн		1074	1074
Үйлчилгээ	Хүн	154	-	154

Төрийн байгууллагад 110 хүн ажиллаж байна.

Ажилгүйдэл

Суманд бүртгэлтэй ажилгүй 72 иргэд бүртгүүлснээс байнгын ажлын байраар 11 хүн, түр ажлын байраар 33 иргэнийг хангасан. Одоогийн байдлаар идэвхитэй ажил хайгч 28 иргэн байна. Орон нутагт ажиллаж амьдарч буй малчин өрхүүд туслах малчин авч ажлын байр бий болгон өрхийн амьжиргааг нэмэгдүүлж байна.

Инженерийн дэд бүтэц

Зам тээвэр. Сумын газар нутагтаа агаарын улсын чанардаа авто зам агаарбагц. Багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Цахилгаан хангамж. Галшар сумын төвийг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдох ажлын эхлэл 1989-1990 онд тавигдаж 15 жилийн дараа буюу 2004 оны 06 сарын 01-нд төвийн эрчим хүчний нэгдсэн системд 850 сая төгрөгийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалттайгаар холбогдсон. Сумын төв дээр 2004 онд баригдсан 110/35/10квт-ийн дэд станц ажиллаж байгаа бөгөөд 2013 онд 0.4 квт-ийн шугам татаж шинэ сууршилын бүсийг цахилгаан хангамжинд холбосон.

Ус хангамж. Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 1 гүний худаг байгаа. Төвлөрсөн ус хангамжийн системд өргөтгөлийн ажлыг эхлүүлж байна.



Дулаан хангамж. Сумын төвд төвлөрсөн уурын зуух ааёбдэг. Үүний дараа, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 9 жилийн сургууль, Цэцэрлэг, Нийслэл дэх өмчийн нийт 6 нам даралтын уурын зуух ажиллаж байна.

Орон сууцны хангамж

Сумын хэмжээнд 25 айлын балкан байшин, 55 айлын тоосгон байшин, 2 айлын сууцны тоосгон байшинг иргэд хувьчлалаар авч, 2013 онд ЖДБДСХөрөнгөөр шинэ суурьшилийн бүсэд амины 3-н орон сууц барьсан. Мөн айл өрхүүд амины сууцны байшин барьж жил ирэх тутам 1-3-аар амины орон сууцны тоог нэмэгдүүлж байна.

Нийгмийн үйлчилгээний барилга, байгууламж

1	Сургууль	хүүхэд	172
2	Сургуулийн дотуур байр	ор	80
3	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв	суралцагч	0
4	Цэцэрлэг	хүүхэд	80
5	Эмнэлэг /хэвтэж эмчлүүлэх/	ор	6
6	Спорт заал	тоо	1
7	Биеийн тамирын талбай	м2	1440
8	Соёлын төв	суудал	300
9	Номын сан	суудал	10
10	Банк	тоо	2
12	Халуун ус	шүршүүр	0

Спортын алдартанууд:

Галшар сумаас төрөн гарсан Даншигийн дөрвөн аварга бөхчүүд:

Дархан аварга Цэдэн, Х.Намжилжав, Даян аварга Чойдорги, Аварга Р.Рэнцэн

Галшар сумаас төрөн гарсан улсын цолтой бөхчүүд:

Улсын арслан Ойдов, Дашжав, заан О.Лувсанбалдан, заан Д.Наваанлуvsан, Жанжны Жагварал, Рэнцэнгийн Дондог

Галшар сумаас төрөн гарсан Анхдагчид:

Рашийн Содномжамц БНМАУ-н онц холбоочин, Жүрмэдийн Дугар БНМАУ-н Шатрын спортын ууган мастер, Донойн Цэвэгмид МУ-н анхны 01 тоот үнэмлэхтэй алдарт уяач, Гэндэндаржаагийн Банзрагч МУ-н Хөлбөмбөгийн ууган мастер, Хардэл бэйсийн харваачид ТББ МУ-н анхны 01 дугаартай сурын холбоо 2013 онд байгуулагдсан. 2016 онд Монгол улсад анх удаа “Галшар адуу”-г үүлдэрээр баталгаажуулсан.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД



Засаг даргын Тамгын газар

- ЗДТГ-ын барилга 1975 онд 20x8 харьцаатай, конторын зориулалттай баригдаж, 2008, 2014 онд урсгал засвар хийгдсэн.
- ЗДТГазар нь улс төрийн 8, төрийн захиргааны 11, төрийн үйлчилгээний 10 нийт 29 ажиллагсадтай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

- Сумын ИТХ-ын дарга П.Энхбаатар
- Сумын Засаг дарга Б.Энхтайван
- Засаг даргын орлогч Г.Дэмчигсүрэн
- ЗДТГ-ын дарга У.Батсуурь
- 1992 онд Монгол улсын “Шинэ үндсэн хууль” батлагдаж засаг захиргааны нэгжийн эршил өөрчлөгдсөн учир АДХ-ын захиргаа гэж байсныг сумын Засаг даргын 1992 оны 11-р сарын 14-ны өдрийн 02 тоот захирамжаар шинэчлэн байгуулагдсан



**Зм өндөр Монголын
хамгийн том
“Морины хусуур”**

СУМЫН ЁСЛОЛ ХҮНДЭТГЭЛИЙН ӨРГӨӨ



**Сумын 9 хөлт
цагаан туг**

Дорнын гүн ухаантан Занын Агваанбалдангийн Нэрэмжит Галшар сумын Ерөнхий боловсролын сургууль

Хан Хэнтий уулын аймгийн анхдугаар хурлаар хошуудад сургууль байгуулах тухай 1924 онд тогтоол гарч Галшар уулын хошуунд 1926 онд анхны сургуулийн эх тавигдаж 1940 онд байгуулагдсан. 1973 онд 8 жилийн сургууль болон өргөжиж 1977 онд Дорнын гүн ухаантан соён гэгээрүүлэгч, Буддын шашинтны ертөнцөд “7 дахь гайхамшиг”-аар нэрлэгдсэн Линсрай гавж, Галшар нутгийн уугуул Занын Агваанбалдангийн нэрэмжит сургууль болсон түүхтэй. 1947-1948 он, 1948-1949 оны хичээлийн жилд хүүхдийг 100% амжилттай суралцуулсан тул аймагтаа тэргүүн байранд орж байсан ба АБТА Ц.Баярсайхан захиралтай Галшар сумын 8 жилийн дунд сургууль нь 1987-1988, 1988-1989 оны хичээлийн жилүүдэд ажил үйлсээрээ аймагтаа хошуучилж тус сургуулийн багш сурган хүмүүжүүлэгчид, суралцагсад, төгсөгчдөөс олон арван шилдэг тэргүүний хүмүүс төрөн гарсан нь түүхэнд тэмдэглэгдсэн юм. Одоогоор 32 багш ажиллагсадтай 100% мэргэжлийн багшаар хангагдсан ба багш нарын 68% нь мэргэжлийн зэрэгтэй.



Галшар сумын 7-р Цэцэрлэг

Манай цэцэрлэг нь 1963 оны 10 сарын 01-нд Буянт-оргил нэгдлийн цэцэрлэг нэртэйгээр анх байгуулагдсан. Анх цэцэрлэг нь эрхлэгч багш, тогооч,



лийг 2016 оны жилийн эцсийн байдлаар гаргасан болно.

асрагч, галч нарын 5 хүний бүрэлдэхүүнтэй 25 хүүхдийн орон тоотой байгуулагдсан. 2014 онд Улсын хөрөнгө оруулалтаар 80 хүүхдийн цэцэрлэгийн барилга баригдаж ашиглалтанд орсон. Эрхлэгч, багш, туслах багш, ня-бо, тогооч, нярав туслах ажилтан, галч гэх мэт 14 хүний орон тоотой ажиллаж байна.

Сүүлийн 6 жилийн үзүүлэлтээр манай цэцэрлэг нь сумын тойргийн хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж бүлэг дүүргэлт явуулж багшийн сургалтын хүүхдийн төлөвлөгөө 97%-100%-тай байна.

Эрүүл мэнд

1928 йй онд анх байгуулагдсан. 1930 оноос бага эмчийн салбар, 1973 йй их эмчийн салбар болсон. 2006 онд анх ЭМТөвийн барилга баригдаж ашиглалтанд орсон бөгөөд хэвтэн эмчлүүлэгчийн 6 ортой, 14 эмч мэргэжилтэнтэй, 8 үйлчилгээний ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.



Соёлын төв

Галшар сумын Соёлын төв нь анх 1941 онд “Хоолойн худаг” гэдэг газар Балдангийн санаачлагаар “Улаан гэр” байгуулагдсан

ᠨᠢᠡᠭᠡᠢ ᠳᠣᠭᠡᠢ барилга 2002 онд шинээр баригдаж ашиглалтад орсон.

- Соёлын төв
 - 200 хүний суудалтай
 - 2014 онд соёлын төвийн барилгад их засвар хийсэн. Нам даралтын уурын зуухтай. Анхны номын сан нь 1960-аад онд Гэлэгсовдын санаачлагаар 1000ш номтойгоор байгуулагдаж байсан ба одоо номын сан 10 хүний суудалтай 7999 ш номын фондтойгоор 464 уншигчдад танхим, явуулын номын сангаар үйлчилгээ хүргэж байна.
- Nî_ëûî ò°â üü 2000 оноос мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаж захирал, хөгжмийн багш, бүжгийн багш, номын санч, үйлчлэгч, галч гэсэн орон тоотогоор сумын нийт хүн амд соёлын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэж ард иргэдийн сэтгэлд нийцсэн үйл ажиллагааг явуулах зорилготой ажиллаж байна.
- 



Ус Цаг уурын шинжилгээний Галшар өртөө



- □ Эрхэм зорилго: Ус Цаг уурын орчны чанартай мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах байгаль цаг агаарын болзошгүй аюул орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлэх, цаг агаар, орчны болон уур амьсгалын нөөцийг бүрэн ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

■ □ Анх 1962 онд Ус цаг уурын харуул нэртэйгээр байгуулагдаж, 1995 оноос Ус Цаг уурын шинжилгээний өртөө болон өргөжснөөс хойш одоог хүртэл хөтөлбөрт болон төлөвлөгөөт ажиглалтуудыг

батлагдсан хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн ажиллаж байна. Одоогоор эрхлэгч, ээлжийн техникч 3, нийт 4 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД

Ахуй үйлчилгээ:

2016 онд Зах зээл бэлчээр болон ОНХСангийн хөрөнгийн санхүүжилтээр байгуулж ашиглалтанд оруулсан. Үүнд оёдол, буудал, үсчин, гоо сайхан, хэвлэлийн үйл ажиллагаа явуулж байна.



Буянт-Оргил булаг хоршоо

Буянт-Оргил хамтын аж ахуй анх 1957 оны 3-р сард Дагва, Л.Өлзийбаяр, Б.Гомбо, Бууран, С.Наваандагва, А.Наваанчүлтэм, Д.Мажигбалдан, Л.Гэндэнжамц, Э.Найдансүрэн нарын 15 хүн санал бодлоо нэгтгэн байгуулагдсан түүхтэй.

Буянт-Оргил булаг хоршоо нь 120 гишүүн 10 ажиллагсадтай 25 малчинтай 4000 гаруй толгой малтай жилд 150 гаруй сая төгрөгний борлуулалт

хийдэг. Өндөрхаан болон сумын төвд худалдаа үйлчилгээний төв ажилладаг ба ХЭРЛЭН цэвэр усны үйлдвэр ажиллаж байна.

Алтат-Ам ХХК

- 2000 онд ЗБН-ээр анх байгуулагдаж
- 2006 онд Алтат Ам ХХК болсноор 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр худалаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Гал сүм ХХК

1999 онд Галшар сумын мал эмнэлгийг ХХДуудлагын худалдаагаар худалдан аваад Галсүм ББН нөхөрлөл нэртэйгээр анх байгуулагдаж Мал эмнэлэгийн үйлчилгээ, хүнс барааны дэлгүүр, малын эмийн худалдаа зэрэг ажил үйлдвэрлэл эрхэлдэг. 5-н багийн 300 гаруй өрхийн, давхардсан тоогоор 300 гаруй мянган толгой малд урьдчилан сэргийлэх тарилгыг хийж малчид ард иргэдэд үйлчилж байна.



Зоригтманлай хоршоо



2004 онд байгуулагдсан. Худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Баатар

1981 онд
1982 оноос
дэлгүүр



/хувиараа бизнес эрхлэгч/

худалдагч мэргэжил эзэмшсэн.
хувиараа төрөл бүрийн барааны
ажиллуулж байна.

Шашин, сүм хийд

Галшар сумын төвд ЛАМРИМ хийдийн барилгыг
2009 онд шинээр барьсан. Мөн тус сумын Хужирт



хэмээх
газарт
байршилтай
Гаданшадав
даржаалин
хийдийг 2013
онд сэргээн
засварласан. Хийдэд улирлын чанартай ном уншлага
хийдэг.



СУМАНД ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮД

- ✓ Орон нутгийн хөгжлийн сан
- ✓ Сум хөгжүүлэх сан
- ✓ Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
- ✓ Амьжиргааг дэмжих сан

Эдгээр төслийн хүрээнд Блокны үйлдвэр, Талх, нарийн боовны цех, Цайны газар, Ахуй үйлчилгээний төв, Эрчимжсэн мал аж ахуй, Монгол гутал, дээл оёх зэргээр жижиг дунд үйлдвэрлэлийг эрхлэж байна.

СУМЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

Тус сум нь **“Хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч сум”** болох зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцөлийг бүрдүүлэх
- Ажлын байрыг 2.3 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- Нийгмийн дэд бүтэц, орон сууцны хангамжийн хувийг дээшлүүлэх

Түүнчлэн:

Галшар суманд:

- Эсгий, эсгий эдлэлийн үйлдвэрлэл

- Махны үйлдвэр
- Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах бүрэн боломжтой.

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН: ЗДТГ-ЫН ДАРГА У.БАТСУУРЬ